

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
СУРГАЛТЫН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2025 оны 12 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт-гэлийн хувь
1	2	3	4	5
Зорилго-1: Дотоод аудитын албаны төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадвар, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, тэднийг хөгжүүлэн мэргэшүүлэх, төрөл бүрийн сургалтад хамруулах				
1	Төрийн албаны тухай хуулийн дагуу албан хаагчдыг сургалтад хамруулах	Төрийн хаагчийн ёс зүй харилцаа, хандлага, цаг ашиглалт сайжирна.	2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар, Авилгатай тэмцэх газартай хамтран дүүргийн төрийн байгууллагуудын албан хаагчдад Авилга ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Энэхүү сургалт, хэлэлцүүлэгт тус албаны дотоод аудитор М.Гүнчинсүрэн, Б.Дуламжав, Д.Гэрэлт-Од, Ш.Жаргалмаа нарын 4 албан хаагч хамрагдсан.	100%
2	Албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэг чадвар дээшлүүлэх чиглэлээр сургалтад хамруулах	Төрийн хаагчийн ажлын бүтээмж дээшилнэ.	1.2025 оны 05 дугаар сарын 28,29-ны өдрүүдэд Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо, Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлөөс Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Монгол Улсын Их Хурлын Ёс зүйн дэгийн байнгын хороо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжил-төрийн албаны манлайлал” сэдэвт нийслэлийн сургалт, зөвлөгөөнд тус албаны ахлах дотоод аудитор Ш.Болормаа, Г.Энхзул нар оролцсон. 2.2025 оны 06 дугаар сарын 9-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын алба, Удирдлагын академитай хамтран “Гэрээний үүрэг, төрөл, онцлог” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Дүүргийн төрийн захиргааны байгууллагууд болон орон нутгийн өмчит байгууллагуудын Хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, гэрээний эрх зүйн зохицуулалт хариуцсан ажилтнуудад “Гэрээний үүрэг, төрөл, онцлог” сэдэвт чадавхижуулах сургалтыг Удирдлагын академийн Эрх зүйн	100%

			тэнхимийн ахлах багш С.Ганццэг удирдан явуулсан бөгөөд тус албаны 2 албан хаагч хамрагдсан. 3.2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Жендэрийн үндэсний хорооны цахим хуудас(www.pcse.gov.mn)-ны удирдах албан тушаалтанд зориулсан цахим сургалтад тус албаны нийт 7 албан хаагч хамрагдаж сертификат, иргэд олон нийтэд зориулсан жендэрийн сургалтад 2 албан хаагч тус тус хамрагдсан.		
3	Монголын Мэргэшсэн нягтлан бодогчийн институтын Аудиторын сургалтад алба хаагчдыг хамруулах (Гэрчилгээтэй)	Төрийн албан хаагчийн мэргэжлийн ур чадвар сайжирна.	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Аудиторын сургалтад тус албаны дотоод аудитор М.Гүнчинсүрэн, Б.Дуламжав, Д.Гэрэлт-Од, Г.Жаргалмаа нар хамрагдаж амжилттай төгсч, Гэрчилгээ авсан.	100%	
4	Архивын Ерөнхий газар болон Нийслэлийн Архивын газраас 2025 онд зохион байгуулах сургалтад холбогдох албан хаагчдыг хамруулах	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт хангагдана.	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс, Архивын хэлтэс хамтран зохион байгуулсан Архив, албан хэрэг хөтлөлттэй холбоотой сургалтад тус албаны 6 албан хаагч хамрагдсан.	100%	
5	Монгол хэлний тухай хуульд 2025 онд төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулна гэж заасны дагуу нийт албан хаагчдыг Монгол бичгийн сургалтад хамруулах	Үндэсний бичгийн сайжирна.	Тус албаны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд батлагдсан сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Дүүргийн Насан туршийн суралцахуйн төвтэй сургалтын гэрээ байгуулж ажилласан. Тус төвийн Туяа багшийн заасан Монгол бичгийн анхан шатны 24 цагийн хичээлийг албан хаагчид амжилттай суралцаж дуусгаад, Батламж гардан авсан.	100%	
6	Албан хаагчдыг эрүүл, зөв хооллолт, эрүүл мэндийн чиглэлээр зохион байгуулсан сургалтад хамруулах	Эрүүл мэндийн боловсрол дээшилнэ.	Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв, Таван толгой ХХК, Дижитал инфосекс ХХК хамтран 2025 оны 11 дүгээр сарын 19-ны өдөр угаарын хийн хордлогоос сэргийлэх, зуухны бүрэн бүтэн байдал, галлагааны аюулгүй байдал, мэдрэгч төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, Хотула аппликейшний үйл ажиллагааны талаар зохион байгуулсан сургалтад тус албаны 6 албан хаагч хамрагдлаа.	50%	
7	Холбогдох мэргэжлийн байгууллагаас зохион байгуулсан сургалтад албан хаагчдыг хамруулах	Төрийн албан ажилын бүтээмж дээшилнэ.	1.2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Цогтбаяр Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газар,	100%	

			нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын алба, аймгуудын газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын үйл ажиллагаанд хийх нэгдсэн хяналт шалгалтын хүрээнд зохион байгуулсан цахим сургалтад тус албаны дотоод аудиторууд бүгд хамрагдсан. 2.2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын албанаас санаачлан Монгол Улсын Сангийн яамтай хамтран зохион байгуулсан “Дотоод аудитын үйл ажиллагааны стандарт, арга зүй” сэдэвт сургалтад тус албаны дарга болон 5 дотоод аудитор нийт 6 албан хаагч хамрагдсан. 3. Монгол Улсын Сангийн яам, Азийн Хөгжлийн банк (АХБ)-тай хамтран “Улсын салбарын дотоод аудиторуудыг чадавхжуулах, олон улсын туршлага солилцох зөвлөгөөн”-ийг 2025 оны 11 дүгээр сарын 13,14-ний өдрүүдэд зохион байгуулсан. Энэхүү сургалтад тус албаны Ахлах дотоод аудитор Ш.Болормаа, Г.Энхзул нар танхимаар, цахимаар 3, нийт 5 дотоод аудитор хамрагдсан.
Зорилго-2: Албан хаагчдын төсөв санхүү, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх			
8	Албан хаагчид хоорондоо харилцан бие биеэсээ суралцаж, сайн туршлагыг солилцох замаар өөрсдийн чадавхийг бэхжүүлэх мэдлэг, мэдээллийн ажлыг зохион байгуулах	Төрийн албан хаагчдын ур чадвар дээшилнэ.	1.2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр “Архив, албан хэрэг хөтлөлт, e-Doc систем ашиглалт” сэдвээр тус албаны архив, бичиг хэрэг, нярав С.Мөнхцэцэг нийт албан хаагчдад сургалт зохион байгуулсан. 2.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн танилцуулга сэдвээр ахлах дотоод аудитор Ш.Болормаа сургалт зохион байгуулсан.
Зорилго-3: Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагын, төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж буй төрийн бус өмчийн цэцэрлэг, сургууль, өрхийн эрүүл мэндийн төвийн удирдлага, санхүүгийн ажилтнуудыг мэргэжил, арга зүйгээр хангах			
9	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагуудын удирдлага, санхүү бүртгэл, дотоод хяналтын нэгжийн ажилтнуудад Монгол Улсын Шилэн дансны тухай хууль болон	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдан, байгууллагын засаглал сайжирна.	2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэстэй хамтран дүүргийн төсвийн байгууллагуудын шууд захирагчид болон нягтлан бодогчдод зориулсан сургалтыг зохион байгуулж, албаны дарга Д.Төмөрбаатар, ахлах дотоод аудитор Ш.Болормаа нар

	шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө зөвлөмж өгөх, зөвлөн туслах, бүсчилсэн сургалтыг зохион байгуулах		Аудитын шалгалтын явцад илэрч байгаа зөрчлүүд, шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулах зэрэг асуудлаар сургалтад оролцогчдод мэдээлэл өгч ажилласан. Зөвлөн туслах ажлыг 121 дүгээр сургууль, 117, 286, 332 дугаар цэцэрлэгийн нийт 4 байгууллагын 25 албан хаагчдад хүргэж ажиллалаа.	
10	Төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байгаа төрийн бус өмчийн цэцэрлэг, сургууль, өрхийн эрүүл мэндийн төвийн удирдлага, санхүүгийн ажилтан, дотоод хяналтын нэгжийн ажилтнуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах	Эрсдэлээс урьдчилан сэргийлж, дотоод хяналтын үйл ажиллагаа сайжирна.	2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн дотоод хяналтын нэгжийн шинээр томилогдсон албан хаагчдад Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын танилцуулга, Дотоод хяналтын нэгжийн төлөвлөгөө боловсруулах зөвлөмж, мэдээлэл өгөх сургалтыг зохион байгуулсан. Энэхүү сургалтад нийт 58 дотоод хяналтын нэгжийн албан хаагчид хамрагдсан.	100%
Албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт гаргах, хэрэгжилтийг хангуулах				
11	Албаны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний биелэлтийг хангуулах, тайлагнах ажлыг зохион байгуулах	Төлөвлөгөөний биелэлт хангагдана.	Албаны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны эхний хагас, жилийн эцсийн байдлаар гаргаж ажилласан.	100%
Биелэлтийн хувь 95%				

БИЕЛЭЛТТЭЙ ТАНИЛЦСАН:
 СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ДОТООД АУДИТЫН
 АЛБАНЫ ДАРГА

БИЕЛЭЛТ ГАРТАСАН:
 ДОТООД АУДИТОР

Б.ДУЛАМЖАВ

5688998 СБТ-475544 3024011267

Д.ТӨМӨРБААТАР